



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/12

Мандалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг байгуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус аймгийн Говь-Угтаал, Луус, Хулд, Өндөршил сумдын төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төслийн 3 дугаар ээлжийн ариун цэврийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Э.Энхмэнд	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Дүүрэнжаргал	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Э.Цэрэннадмид	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Б.Оюунсүвд	(Барилгын хөгжлийн төвийн Барилга, Байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер)
	Г.Билгүүн	(Барилгын хөгжлийн төвийн Барилга, Байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер)
	Ц.Уранбямба	(Аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
	А.Ганхуяг	(Зураг төсөл зохиогч “Стийл проект” ХХК-ийн захирал)
	Д.Нямдаваа	(Зураг төсөл зохиогч “Стийл проект” ХХК-ийн архитектор)
	Д.Нэргүй	(Гүйцэтгэгч “Ашид бьюлдинг” ХХК-ийн захирал)
	Н.Долгоржав	(Ашиглагч Луус сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал)

М.Үүрийнбаяр	(Ашиглагч Луус сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)
Ц.Баянзөв	(Ашиглагч Хулд сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал)
Г.Алдармаа	(Ашиглагч Хулд сумын хүүхдийн цэцэрлэгийн аргазүйч)
Д.Дулам	(Ашиглагч Говь-Угтаал сумын ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч)
Г.Мөнхсоёл	(Ашиглагч Говь-Угтаал сумын хүүхдийн цэцэрлэгийн аргазүйч)
Н.Цэрэндулам	(Ашиглагч Өндөршил сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал)
Т.Уранбайгаль	(Засаг даргын Тамгын газрын архивын тасгийн дарга)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Э.Энхмэнд)-т даалгасугай

ДАРГА



Э.ЧАГНААДОРЖ